

БАТЛАВ: УЛААНБАДРАХ СУМЫН ЗАСАГ ДАРГА

Ц.ЭРХЭМБОЛД

Огноо: 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдөр

**Төслийн нэр: УЛААНБАДРАХ СУМЫН 4-Р БАГИЙН “ТӨВ ГУДАМЖИД КАМЕР  
УГСАРЧ СУУРИЛУУЛАХ АЖИЛ”**

**Төслийн дугаар: ДГАУБСЗДТГ/202012004**

**Улаанбадрах сум  
2020 он**

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Тендер зарлах огноо: 2020-03-11

*Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Засаг даргын Тамгын газар* нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос Улаанбадрах сумын 4-р багийн *“Төв гудамжид камер угсарч суурилуулах ажил”-ын* гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны стандарт, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 10:00 цагаас өмнө [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар цахимаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 10 цаг 10 минутанд нээнэ.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Засаг даргын Тамгын газар

Утас: 99829812, 96119693

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |   |
|---|---|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | <b>1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.</b>  |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | <b>2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.</b><br><b>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.</b>  |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | <b>3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:</b><br><b>(а) Үнийн санал;</b><br><b>(б) Оролцогч компанийн танилцуулга</b><br><b>(в) Бараа нийлүүлэх хуваарь;</b><br><b>(г) Чадварын мэдээлэл болон бусад баримт бичиг;</b><br><b>(д) Ижил төрлийн бараа, нийлүүлсэн туршлага гэрээ холбогдох тайлангийн хуулбар, хүлээлгэн өгсөн акт 2018-2019 оноор</b><br><b>(е) Шаардлагатай тусгай зөвшөөрөл “шаардахгүй”</b><br><b>(ё) -Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар /гадаад худалдаа эрхлэх/ чиг үүрэгтэй байх.</b><br><b>-Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл</b><br><b>-Харьяалагдах банкны тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх</b><br><b>- Татварын тайлан /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх</b><br><b>- Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт /өргүй байх/</b><br><b>-Гэрээг гүйцэтгэгч удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар.</b><br><b>/ж/ Тендерийн баталгаа ирүүлэхгүй.</b> |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | <b>4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.</b>   |
| <b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | <b>5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.</b><br><b>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан</b>   |





арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.


- |   |  |
|---|--|
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа      | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх       | <p>7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.</p> <p>7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь <i>ТШӨХ-д</i> заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.</p> <p>7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.</p> |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.  |

**Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

<b>ТӨӨЗ-ны холбогдох заалт</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>
<b>ТӨӨЗ 1.1</b>	<p>Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан /шаардлагатай бол аудитын дүгнэлтийн хамт/;</p> <p>Сүүлийн 2 жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, хүлээлгэн өгсөн акт/;</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: Гадаад худалдаа шаардлагатай.</p>
<b>ТӨӨЗ 2.1</b>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <i>Улаанбадрах сум 4-р баг, Засаг даргын Тамгын газар</i></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <i>Сумын Засаг даргын орлогчийн албан өрөөнд</i></p> <p>Тендер хүлээн авах хаяг: <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a></p> <p>Огноо: <i>2020 оны 03 дугаар сарын 23-ны өдөр</i></p> <p>Цаг: <i>10 цаг 00 минут</i></p>
<b>ТӨӨЗ 2.1</b>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <i>Улаанбадрах сумын 4-р баг, Засаг даргын Тамгын газар</i></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <i>Улаанбадрах сумын Засаг даргын орлогчийн албан өрөөнд</i></p> <p>Огноо: <i>2020 оны 03 дугаар сарын 23-ны өдөр</i></p> <p>Цаг: <i>10 цаг 10 минут /www.tender.gov.mn/ цахим хаягаар нээнэ.</i></p>
<b>ТӨӨЗ 6.2</b>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: ДГАУБСЗДТГ/202012004]</p>

**Дөрөв. СУМЫН 4 ДҮГЭЭР БАГИЙН ТӨВИЙН ГУДАМЖИД КАМЕР УГСАРЧ  
СУУРИЛУУЛАХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ**

д/д	Бүтээгдэхүүний нэр төрөл, зураг	Бүтээгдэхүүний нэр төрөл, зураг	Үзүүлэлт	Тоо
1	Камерын антен		5км дүрс дамжуулах монголын эрс тэс цаг уурт тохирсон тэсвэртэй саадгүй ажиллах	10ш
2	Камерын бичигч төхөөрөмж		16 оролттой 265H-264H	1ш
3	Дэлгэц 49 inch LED	Дэлгэц 49 inch LED 	Skyworth	1ш
4	Камер		8mp 360 градус эргэж 18 татах хүчин чадалтай	10ш
5	Бичлэг хадгалах санах ой /хард/		8TB	4ш
6	Свитч буюу холбогч төхөөрөмж		Свитч 5 оролттой	2ш
7	Кабелийн утас		Гадаа , Дотор бат бөх 5X6 хэмжээтэй камерын зориулалтын кабел	100m
8	Хайрцаг		Гадаа , Дотор зориулагдсан төмөр	10ш

9	Гадаа утасны хоолой , дотор далдлагч			1 боодол
10	Суурин компьютер		/dell/	1 ш
11	DJI Mavic 2 pro дрон	Дроны үзүүлэлтийг хавсаргав	Удирдах зай 8 км, Өндрийн хязгаар 500 метр, Нисэх хугацаа 31 минут, Дээд хурд 72км/цаг	багц

*Тоног төхөөрөмжийг суурилуулж хэвийн ажиллагаанд оруулж хүлээлгэн өгөх*

## ДРОНЫ ҮЗҮҮЛЭЛТ



"Роботийгл Анмэнэд Айр Виклз" ХХК

### Үнийн санал

№


Огноо: 2019 оны 12-р сарын 05 ны өдөр

Үйлчилүүлэгч:



Authorized DEALER

[www.drone.mn](http://www.drone.mn)

Бүтээгдэхүүн					
№	Барааны нэр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ НӨАТ тай /төг/	Үзүүлэлт	Зураг ба Холбоос
1	DJI Mavic 2 pro дрон	Багц	4 280 000	<p>MAVIC 2 PRO дрон нь зөвхөндөгээрээ бусдаас илцлэг ба авч явахад авсаархан, хөнгөнхөн мөн хүчирхэг юм. ActiveTrack 2 хөдөлгөөнт биет таниулан автоматаар дагуулан нисэх болон Tap FLY буюу хуруугаар зааж автоматаар нисэх зэрэг 12 төрлийн автомат нислэгийн горимуудтай. Агаарт 31 минут хүртэл нисэх ба бүх талбаа саад мэдрэн анх хөөрсөн цэргүүгээ аюулгүй ухаалагаар буцаж ирэх юм. L1D-20c Hasselblad камер нь Hasselblad Natural Colour Solution (HNCS) технологитой бөгөөд энэ нь 20MP-ээр гайхалтай зураг авахад тань туслах болно.</p> <p>УДИРДАХ ЗАЙ: 8 км ӨНДРИЙН ХЯЗГААР: 500 метр НИСЭХ ХУГАЦАА: 31 минут ДЭЭД ХУРД: 72 км/цаг ЖИН: 907 грамм</p> <p>СААД МЭДРЭГЧ: Бүх талдаа 30метрээс САЛХИНД ТЭСВЭР: 12 метр/секунд БИЧЛЭГИЙН ЧАНАР: 4K 30fps, 2.7K, 1080P ВИДЕО ФОРМАТ: MP4, MOV ЗУРГИЙН ФОРМАТ: JPEG, DNG</p> <p><b>Нэмэлт функц</b> Хөөрсөн цэргүү буцажирэх GPS координатаар автоматаар нисэх Хөдөлж буй объект автоматаар дагаж нисэх Саад мэдрэгч сенсор Гараар даллахад автоматаар зураг авна Ocusync дотроо дэлгэцтэй нүдний шилээр харах боломжтой</p>	
3	Fly More Combo Kit	Багц	1 100 000	<p>Fly More Combo хэрэгслүүдийн багц: Баттерей 2 ширхэг, Цүх нэг ширхэг, Санс 2 хос 4ширхэг, Автомашны цэнэглэгч нэгширхэг, Power Bank хувиргарч нэг ширхэг, 4 баттерей цэнэглэх үүрэг ширхэг.</p>	
4	Батерей	Ширхэг	418 000	3830 mAh багтаамжтай Li-Po 11.4V батерей	
5	Машины цэнэглэгч	Ширхэг	187 000	Машины цэнэглэгч. Мөн 12В-т цэнэглэж болно.	

## ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тооцоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Гүйцэтгэх ажил нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
4. Ажил гүйцэтгэх хугацаа \_\_\_\_\_ хэд хоног байна.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:



## **Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ**

- |   |  |
|---|--|
| <b>1. Шалгах болон турших</b>                             | <b>1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.</b>   |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b> | <b>2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.</b> |
| <b>3. Оюуны өмчийн эрх</b>                                | <b>3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.</b>  |
| <b>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх</b>     | <b>4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.</b>  |
| <b>5. Баталгаат засварын хугацаа</b>                      | <b>5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [1] жил байна.</b>  |
| <b>6. Гэрээнд өөрчлөлт оруулах</b>                        | <b>6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.</b>   |
| <b>7. Төлбөр</b>  | <b>7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [Ажлын 21] хоногийн дотор шуурхай хийнэ.</b>   |
| <b>8. Бараа нийлүүлэх хуваарь</b>                         | <b>8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөж тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалтын ажлыг хийж гүйцэтгэнэ.</b>   |

- |  |   |
|--|---|
| 9. Алданги<br>оногдуулах                         | 9.1. <b>Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.</b> |
| 10. Үүргээ<br>биелүүлээгүй-гээс гэрээг<br>цуцлах | 10.1. <b>Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.</b>  |
| 11. Маргааныг<br>шийдвэрлэх                      | 11.1. <b>Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.</b>   |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| 1. <b>Шалгах болон турших (ГЕН – 1)</b>                             | 1.1. [Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: Дорноговь аймгийн Улаанбадрах сумын 4 дүгээр багийн “Төвийн гудамжид камер угсарч суурилуулах ажил” ДГАУБСЗДТГ/202012004]  |
| 2. <b>Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b> | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ul style="list-style-type: none"> <li>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;</li> <li>2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;</li> <li>3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;</li> <li>4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;</li> <li>5) барааны гарал үүслийн гэрчилгээ.</li> </ul> |

Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.

- 3. Баталгаат засвар (ГЕН-5)**      5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.  
[1 жилийн баталгаат хугацаатай байна]
- 4. Төлбөр (ГЕН – 7)**      7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:  
  
Гэрээний үнийн дүнгийн **100** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>1</sup>**      9.1. Алданги оногдуулах хувь: **[0.1%]**  
  
Алдангийн нийт дүн: **[10%]**
-

БАТЛАВ.

**ЗАХИАЛАГЧ**

**ГҮЙЦЭТГЭГЧ**

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_  
(Гарын үсэг)

\_\_\_\_\_  
(Гарын үсэг)

\_\_\_\_\_  
(Албан тушаал)

\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>2</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

#### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

#### ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

\_\_\_\_\_

